



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 01

Мөрөн

**Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн
албан татварын хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д”, Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймагт мөрдөгдөх авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан албан татварын хувь хэмжээг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 42 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

119100009

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2020 оны 05 дугаар сарын 20-ны
өдрийн ээлжит бус XII хуралдааны
1 дүгээр тогтоолын хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ
ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН МЭДЭЭЛЭЛ

/төгрөгөөр/

№	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Татварын хэмжээ /Хуульд заасан хязгаар/	Аймгийн ИТХ-ын ээлжит бус XII Хуралдааны Тогтоол	
1	2 дугуйтай мотоцикл	1800-2700	2000	
2	3 дугуйтай мотоцикл	2800-4200	3000	
3	Суудлын автомашин:			
4	Үүнээс: а. 2000 см3 хүртэл багтаамжтай	14000-42000	24000	
5		б. 2001-3000 см3	32000-72000	45000
6		в. 3001дээш см3	60000-90000	66000
7	Микро автобус /15 хүртэл суудалтай/	28000-42000	32000	
8	Автобус	40000-60000	50000	
8	Ачааны автомашин:			
10	Үүнээс:	1 хүртэл тн-ын даацтай	20000-30000	25000
11		1-2 тн-ын даацтай	28000-42000	32000
12		2-3 тн-ын даацтай	36000-54000	42000
13		3-5 тн-ын даацтай	44000-66000	50000
14		5-8 тн-ын даацтай	64000-96000	80000
15		8-10 тн-ын даацтай	72000-108000	92000
16		10-20 тн-ын даацтай	80000-120000	100000
17		20-30 тн-ын даацтай	120000-180000	150000
18		30-40 тн-ын даацтай	160000-240000	220000
19		40-50 тн-ын даацтай	200000-300000	280000
20		50-60 тн-ын даацтай	240000-360000	320000
21		60-70 тн-ын даацтай	280000-420000	420000